

“Инженеринг авардс” компанийн танилцуулга



ИНЖЕНЕРИНГ АВАРДС КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

ХОЛБОО БАРИХ ХАЯГ

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13-р хороолол
18-р хороо, Манлайбаатар Дамдинсүрэнийн гудамж
25/3-ийн 13380, 501 тоот

Утас: +976-88129889
+976-91399889

Е-мэйл хаяг: office@en-aw.com

Веб хаяг: <http://www.awards.myhouse.mn>

"ИНЖЕНЕРИНГ АВАРДС" ХХК-ийн товч танилцуулга

“Инженеринг Авардс” ХХК нь 2014 онд анх гадаад, дотоод худалдааны чиглэлээр үүсгэн байгуулагдсан. 2015 оноос эхлэн “Барилга хот байгуулалтын яам”-наас олгодог тусгай зөвшөөрлийн дагуу Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт, Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил, Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, Холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар, шугам сүлжээний угсралт хийх гэсэн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байгуулагдсан цагаасаа өнөөдрийг хүртэл барилгын цахилгаан угсралт, холбоо дохиолол, худалдааны чиглэлээр тасралтгүй үйл ажиллагаагаа амжилттайгаар явуулж байна.

Бид Монголын барилгын салбарт үйл ажиллагаагаа өргөжүүлэн явуулж буй үндэсний бүтээн байгуулагч компаниудын нэг бөгөөд манай компани нь барилга угсралт, цахилгаан, холбоо дохиоллын тусгай зөвшөөрөлтэй бөгөөд ажлыг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэдэг. Мөн барилгын материал худалдааны салбарт ч багагүй хувь нэмэр оруулсаар ирсэн юм.

Үйл ажиллагаагаа явуулахдаа чанарыг эрхэмлэн Монгол улсад мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм, Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2008-ийн шаардлага, Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын Олон улсын стандарт OHSAS 18001:2007-ийн шаардлага, төслийн удирдлагын ISO 21500 зааварчилгааг төслийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хичээнгүйлэн ажилладаг.

Бид нийт 30 гаруй Монгол ажилтнуудтай бөгөөд Монгол улсын мэргэшсэн инженер, барилгын инженер, цахилгааны инженер, холбооны инженер, механик инженер зэрэг туршлагатай инженерүүдээс гадна барилгын төрөл бүрийн мэргэжлийн 3,4 дүгээр зэрэгтэй ажилтан болон маркетингийн тэргүүлэгч багийг бүрдүүлж үндэсний татвар төлөгч байгууллага болж өргөжиж байна.

БИДНИЙ ЗОРИЛГО:

“Инженеринг авардс” ХХК нь чанар, үйлдвэрлэлийн түвшин, хөгжил, технологийн хэрэглээ болон үйлчлүүлэгчтэй уян хатан харьцах харьцаа, хамтын ажиллагаагаар дотоодын бусад өрсөлдөгчөөсөө ялгагдахуйц түвшинд авч явахыг эрмэлздэг ба цахилгааны болон барилгын бүхий л тоног төхөөрөмжийг угсран суурьлуулж, чанартай ханган нийлүүлэгч болохоор зорьж байна.

Бид үйлчлүүлэгч худалдан авагчдадаа чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангахын зэрэгцээ шударга өрсөлдөөний зарчмыг баримтлан зах зээл дэх байр сууриа улам бататгахын төлөө оргил өөд тэмүүлэн ажилладаг бөгөөд үндэсний тэргүүлэгч компани, Монгол орны хөгжил дэвшилд хувь нэмэр оруулагч компани байх зорилготой.

Бид дээрх ажлыг дадлага туршлага, найдвартай, тасралтгүй үйл ажиллагааг харилцагч нартаа үзүүлж, итгэлтэй түнш болон харилцагчдынхаа хүрээг улам тэлж барилгын үйлдвэрлэл, худалдаа эрхэлдэг хувь хүн компаниудтай холбоо тогтоон хамтран ажиллахад бэлэн байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

- Барилга угсралт, дотор засал чимэглэл
- Гадаад, дотоод худалдаа, суурилуулалт
- Цахилгаан, холбоо, дохиолол хамгаалалт

“ИНЖЕНЕРИНГ АВАРДС” ХХК
Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 18-р хороо
Манлайбаатар, Дамдинсүрэнгийн гудамж, 25/3 ийн 13380, 501 тоот
Утас/факс: 88129889, 91399889,
E-mail: office@en-aw.com

“ИНЖЕНЕРИНГ АВАРДС” ХХК-ИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Үзүүлэлт	Тайлбар
1	Оноосон нэр	“ИНЖЕНЕРИНГ АВАРДС” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар:	901150088
3	Регистрийн дугаар:	5871751
4	Өмчийн хэлбэр	Хувийн
5	Оршиж буй газрын хаяг	Баянзүрх дүүрэг, 18-р хороо, Манлайбаатар, Дамдинсүрэнгийн гудамж, 25/3-ийн 13380, 501 тоот
6	Шуудангийн хайрцаг, харилцах утас, факс, E-mail	88129889, 91399889 office@en-aw.com
7	Эрхэлдэг ажлын үндсэн чиглэл	Барилгын цахилгаан угсралт, холбоо дохиолол, цахилгааны ажил
8	Харьяалагдах татварын алба	Татварын алба
9	Байгуулагдсан он:	2014.08.20

ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

- 2014 он Үндэсний Бүтээн байгуулалтын корпорацийн Буян ухаа 2 хорооллын Хаг Ерөө ХХК туслан гүйцэтгэгчээр 2 орон сууцны цахилгааны угсралт холбоо дохиоллын сүвэгчилэл хийж гүйцэтгэсэн.
- 2015 он Роял хаус ХХК Пеас товн 56 айлын орон сууцны А блокын иж бүрэн дотор заслын ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд саун, дэлгүүр, хоолны газар, 56 айлын дотор заслын ажлыг 6 сарын дотор дуусгаж улсын комисст хүлээлгэж өгсөн.
- 2016 он “Морнинг Старланд” ХХК-ийн 315 айлын 12000 мкв бүхий орон сууцны барилгын дотор цахилгаан ажил сувагчилал, кабел татах, тоног төхөөрөмж суурилуулах, газардуулга хийх, нормын дагуу угсрах ажлын хийж гүйцэтгэсэн.
- Шинэ Сибирь Энержи ХХК Му Town цогцолбор хотхоны хүрээнд В-1 блок 16 давхарын заслын ажил хийж гүйцэтгэсэн.



ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ФОТО МЭДЭЭЛЭЛ



ХАРИЛЦАГЧ БАЙГУУЛЛАГУУД

ДОТООДЫН БАЙГУУЛЛАГА



ГАДААД ОРНЫ БАЙГУУЛЛАГА

